

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023
ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: СЭА-2024/26-16-ШТА-ГА

ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ
ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН, ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР БҮРЭН
БҮРДЭЭГҮЙ ЗЭРЭГ ШАЛТГААНЫ УЛМААС ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 31.5
ХУВЬ НЬ ДУТУУ БОЛОН ОГТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

Сүхбаатар сум 2024 он



Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Болор

Утас: 70362442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Аудитор Д.Чулуунцэцэг

Утас: 70362442 Цахим хаяг: chuluuntsetsegd@audit.gov.mn

Аудитор О.Анхбаяр

Утас: 70362442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх?

1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?

Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх?

2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн, үр нөлөөтэй байна уу?

2.3. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна уу?

Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх?

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?

3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товьёг:

Хүснэгт 1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт
Хүснэгт 2. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн гүйцэтгэл
Хүснэгт 3. ОНХС-ийн хуваарилалт
Хүснэгт 4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа

Дүрслэлийн товьёг:

Дүрслэл 1. Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэл
Дүрслэл 2. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэл
Дүрслэл 3. Удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл байршуулалт

Хавсралтын товьёг:

Хавсралт 1. ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 2. МТТАТ-ын орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн судалгаа
Хавсралт 3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 4. Магадалшгүй ажлын тэмдэглэл үйлдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 5. Алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 6. Анхан шатны баримтын бүрдлийг хангалгүйгээр санхүүжилтийг олгосон төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 7. Шилэн дансанд байршуулсан мэдээллийн судалгаа

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/152 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын баримт материал болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, багийн ИНХ, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, СТСХ, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020 “Төрийн аудит. Чанарын хяналт”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”,
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, Ц.Отгонбаяр, аудитор Д.Чулуунцэцэг, О.Анхбаяр, Б.Наранцэцэг, Ц.Ундраа, Б.Бат-Орших нар 2024 оны 05 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж **орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор** улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

“Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай” хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 20,328.8 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд хийсэн хэлэлцээрийн дагуу “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлж, хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай” хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2023 онд Сэлэнгэ аймгийн сумдын ОНХС-д 1,102.7 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталжээ.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулахаар заажээ.

Аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлага мэдээллийн системд бүрэн оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад 9 сум нь 2,903.9 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээний мэдээллийг нээлттэй ил тод мэдээлээгүй байна.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 32,914.6 сая төгрөгийн 366 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 251 төсөл, арга хэмжээ буюу 68.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 төсөл, арга хэмжээ буюу 7.7 хувь нь дутуу хэрэгжсэн, 87 төсөл, арга хэмжээ буюу 23.8 хувь нь огт хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ АШИГЛААГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАТАЛСААР БАЙНА.

1.1 ОНХС-д малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төлөвлөж, төвлөрүүлээгүй байна.

1.1.1 “Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг **16,630.7** сая төгрөгөөр баталсан бол 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр **3,698.1** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **20,328.8** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

1.1.2 Аймаг, сумдын ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 18,753.2 сая төгрөг буюу 66.8 хувийг ОНХНС-аас, 472.8 сая төгрөг буюу 1.7 хувийг улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс, 1,102.8 сая төгрөг буюу 3.9 хувийг Тогтвортой амьжиргаа-3 төслийн урамшууллаас, 2,760.1 сая төгрөг буюу 9.8 хувийг ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс, 1,386.1 сая төгрөг буюу 4.9 хувийг хандив тусламжийн орлогоос, 3,607.5 сая төгрөг буюу 12.9 хувийг МТТАТ-ын орлогоос зэрэг нийт **28,082.5** сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт

сая төгрөг/

№	Аймаг, сумдын нэр	ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг				Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр			Нийт эх үүсвэр
		Орлогын шилжүүлэг	АМХТЗ 100%	АМАТЗ 50%	"Тогтвортой амьжиргаа-3"-аас урамшуулал	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	Хандив тусламж	Малын тоо, толгойн албан татвар	
1	Алтанбулаг	331.4			49.0	111.7		45.0	537.1
2	Баруунбүрэн	441.9	0.1			75.3		315.0	832.3
3	Баянгол	537.4	6.3	85.8	75.7	134.5		298.5	1,138.2
4	Ерөө	935.4	0.1	132.7	130.8	153.1	1,386.1	158.3	2,896.5
5	Жавхлант	179.5			26.3	8.5		280.3	494.6
6	Зүүнбүрэн	213.3			29.4	14.7		234.4	491.8
7	Мандал	2,547.2	0.4	112.9	437.6	232.1		208.6	3,538.8
8	Орхон	251.0	0.9	0.6	36.6			156.9	446.0
9	Орхонтуул	520.7	22.1	50.8		112.7		408.0	1,114.3
10	Сайхан	720.0		2.3	103.0	7.3		226.0	1,058.6
11	Сант	253.7				15.0		171.7	440.3
12	Сүхбаатар	775.1				281.0		47.4	1,103.5
13	Түшиг	287.9		10.6		72.7		82.6	453.8
14	Хушаат	250.2			34.6	0.1		240.0	524.9
15	Хүдэр	388.0	11.7	35.4	61.9	195.1		76.0	768.2
16	Цагааннуур	539.6			89.9	91.3		544.8	1,265.6

17	Шаамар	204.3		0.1	28.0			114.0	346.4
18	Аймгийн ОНХС	9,376.6				1,255.0			10,631.6
	НИЙТ	18,753.2	41.6	431.2	1,102.8	2,760.1	1,386.1	3,607.5	28,082.5

Эх сурвалж: МУ-ын 2023 оны төсвийн тухай хууль, аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

1.1.3 Гүйцэтгэлээр 2023 онд ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгээс 20,170.6 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 243.5 сая төгрөг, дотоод, гадаадын хандив тусламжаас 65.0 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 8.1 сая төгрөг, МТТАТ-ын орлогоос 2,154.8 зэрэг нийт **22,642.0** сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээр орлогын төлөвлөгөө **80.6** хувьтай тайлагнагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийн гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Аймаг, сумдын нэр	ОНХНС болон улсын төсвөөс				Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр				Нийт эх үүсвэр
		Орлогын шилжүүлэг	АМХТЗ 100%	АМАТЗ 50%	"Тогтвортой амьжиргаа-3"-аас урамшуулал	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	Хандив тусламж	Бусад орлого	Малын тоо, толгойн албан татвар	
1	Алтанбулаг	331.4			49.0	5.0			45.0	430.4
2	Баруунбүрэн	441.9	0.1						170.3	612.3
3	Баянгол	537.4	6.3	85.8	75.7	126.9			171.6	1,003.7
4	Ерөө	935.4	0.1	132.7	130.8	52.1		0.5	109.8	1,361.4
5	Жавхлант	179.5			26.3	57.5			125.2	388.5
6	Зүүнбүрэн	213.3			29.4				67.4	310.1
7	Мандал	2,547.6	0.1	112.9	437.6				208.6	3,306.8
8	Орхон	251.0	0.9	0.6	36.6	0.9			156.9	446.9
9	Орхонтуул	520.7	22.1	50.8	-	1.0			242.1	836.7
10	Сайхан	720.0		2.3	103.0				226.0	1,051.3
11	Сант	253.7							91.3	345.0
12	Сүхбаатар	775.1						7.5	14.5	797.1
13	Түшиг	287.9		10.6			25.0	0.1	68.6	392.2
14	Хушаат	250.2			34.6				202.5	487.3
15	Хүдэр	388.0	11.7	35.4	61.9		40.0		30.5	567.5
16	Цагааннуур	539.6			89.9				132.1	761.6
17	Шаамар	204.3		0.1	28.0				92.4	324.8
18	Аймгийн ОНХС	9,218.4								9,218.4
	НИЙТ	18,595.4	41.3	431.2	1,102.8	243.4	65.0	8.1	2,154.8	22,642.0

Эх сурвалж: Аймаг, сумын ОНХС-ийн харилцах дансны хуулиуд

1.1.4 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор Түшиг сумын ОНХС-д “Шар нарст” ХХК-аас 25.0 сая төгрөг, Хүдэр сумын ОНХС-д “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХХК-иас 40.0 сая төгрөгийн хандивын орлогыг төвлөрүүлсэн байна.

1.1.5 Харин Бугант, Дулаанхаан тосгоны захирагчийн алба нь иргэн, аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив, тусламжийн орлогыг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.2.5¹ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн алба нь нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан иргэдээс 14.4 сая төгрөгийн хандив төвлөрүүлж зарцуулсан,
- Шаамар сумын Дулаанхаан тосгоны Захирагчийн алба нь Монголиан транс ложистик компаниас ахмадын баярын зардалд зориулж 4.0 сая төгрөг.

1.1.6 ОНХНС болон улсын төсвийн эх үүсвэрээс Сэлэнгэ аймагт хуваарилсан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2², 59.3³, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тооцож хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. ОНХС-ийн хуваарилалт

/сая төгрөг/

№	Санхүүжилт олгох аймаг, сумд	ОНХНС-аас				ОНХС-д олгох орлогын шилжүүлгээс		Тогтвортой амьжиргаа-3 төслөөс урамшуулал	Орлогын шилжүүл- гийн дүн
		Сумын ОНХС			Аймгийн ОНХС	АМХТЗ	АМАТЗ		
		Хүн ам 40%	Алсл- алт 30%	Нутаг дэвсгэр 30%					
1	Алтанбулаг	164.2	23.6	143.6				49.0	380.4
2	Баруунбүрэн	107.5	142.0	192.4		0.1			442.0
3	Баянгол	196.2	206.2	135.1		6.3	85.8	75.6	705.2
4	Ерөө	243.2	131.5	560.7		0.1	132.7	130.8	1,199.0
5	Жавхлант	70.6	27.6	81.3				26.3	205.8
6	Зүүнбүрэн	103.1	27.9	82.4				29.3	242.7
7	Мандал	930.6	1,285.5	331.1		0.4	112.9	437.6	3,098.1
8	Орхон	78.8	82.9	89.3		0.9	0.6	36.6	289.1
9	Орхонтуул	131.0	188.7	201.0		22.1	50.8		593.6
10	Сайхан	321.4	308.9	89.7			2.3	103.0	825.3
11	Сант	74.2	84.7	94.8					253.7
12	Сүхбаатар	772.0	-	3.1					775.1
13	Түшиг	64.9	52.6	170.4			10.6		298.5
14	Хушаат	73.2	39.6	137.4				34.6	284.8
15	Хүдэр	98.9	95.0	194.0		11.7	35.4	62.0	497.0
16	Цагааннуур	181.0	97.8	260.8				89.9	629.5
17	Шаамар	139.9	18.5	45.9			0.1	28.0	232.4
18	Аймаг				9,376.6				9,376.6
	Нийт дүн	3,750.7	2,813.0	2,813.0	9,376.6	41.6	431.2	1,102.7	20,328.8

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

¹ 60.2. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

² Аймаг, нийслэл нь ОНХС-аас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум, дүүргийн ОНХС-д хуваарилна: 59.2.2. энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах.

³ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно: 59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс; 59.3.2.хүн амын тоо; 59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ; 59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

1.1.7 Дээрх хүснэгтээс харахад ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийн 46.1 хувь буюу 9,376.6 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 53.9 хувь буюу 10,952.2 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

1.1.8 ОНХС-ийн орлогын бүрэлдэхүүн хэсэг болох МТТАТ-ыг 2022 оны жилийн эцэст аймгийн дүнгээр тоологдсон нийт 1.9 сая толгой малд сумдын ИТХ-аас баталсан албан татварын хувь хэмжээгээр тооцож, 2023 онд 2,896.0 сая төгрөг ногдуулахаас 5 сум 1.3-80.4 сая төгрөгөөр илүү, 9 сум нийт 0.6-91.0 сая төгрөгөөр дутуу тооцсоноос аймгийн дүнгээр 102.8 сая төгрөгөөр дутуу ногдуулсан байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харах/*

1.1.9 Ингэснээр 2,793.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,178.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 614.8 сая төгрөгөөр тасарсан.

1.1.10 МТТАТ-ын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Алтанбулаг сум 1.0 сая төгрөг, Мандал сум 32.4 сая төгрөгөөр дутуу, 10 сум урьд оны үлдэгдлээс 847.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөж, нийт 3,607.5 сая төгрөгийн 136 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна.

1.1.11 МТТАТ-ын орлогын төлөвлөгөө тасарсан, урьд оны үлдэгдлийг төвлөрүүлээгүй зэргээс шалтгаалан ОНХС-ийн дансанд 1,452.7 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь сангийн эх үүсвэр дутагдах, төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх үндсэн нөхцөл болсон байна.

1.2 ***Иргэдийн санал аваагүй, зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй, чиг үүрэгт үл хамаарах төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталдаг зөрчил бүрэн арилахгүй байна.***

Аймгийн ОНХС:

1.2.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 141 дугаар тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр нийт 14,247.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл, арга хэмжээг эцэслэн баталсны 1,146.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих бол 13,101.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 54 нь шинээр эхлэх төсөл арга хэмжээ байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав/*

1.2.2 Аймаг нь ОНХС-ийн үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн дагуу төлөвлөөгүй байна.

1.2.3 Өөрөөр хэлбэл ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулаагүйгээс сумдаас ирүүлсэн төсөл, арга хэмжээг иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн болон аймгийн хөгжлийн бодлого чиглэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан

эсэхийг тооцох, урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэх, иргэд олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажил огт хийгдээгүй байна.

1.2.4 Аймаг нь иргэдийн саналыг авч, эрэмбэлэгдээгүй **1,280.4** сая төгрөгийн төсөвт өртөг бүхий **9** төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- *Гудамж талбайн тохижилт /Ерөө сум/ 115.0 сая төгрөг,*
- *Моргийн барилгын их засвар /Орхонтуул сум, Рашаант тосгон/ 55.0 сая төгрөг,*
- *Номт хан өрхийн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Сүхбаатар 4-р баг Баянхан/ 173.0 сая төгрөг,*
- *Экскаватор авах /Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ/ 350.0 сая төгрөг,*
- *Аймгийн нэгдсэн музейн дээврийн засварын ажил 102.1 сая төгрөг,*
- *Сургуулийн их засвар /Мандал сум, 3-р сургууль/ 300.0 сая төгрөг,*
- *Гемодиализийн эмчилгээний ус цэвэршүүлэх аппарат /Нэгдсэн эмнэлэг/ 35.0 сая төгрөг*
- *Нийтийн эзэмшлийн байрнуудын дээврийн засвар / Сүхбаатар 7-р баг/ 105.0 сая төгрөг,*
- *Зам засвар /Сүхбаатар сум/ 45.3 сая төгрөг зэрэг 9 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.*

1.2.5 Аймгийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх нийт 2,109.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 , Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав/

Сумдын ОНХС:

1.2.6 Сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр нийт 18,666.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 306 төсөл, арга хэмжээг эцэслэн баталсны 1,955.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 нь өмнөх оноос шилжсэн бол 16,711.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 282 нь шинээр эхлэх төсөл арга хэмжээ байна.

1.2.7 Багуудын ИНХ-аас ирүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, эрэмбэлэлтэй холбоотой баримт материалыг тулган баталгаажуулахад төслийн танилцуулгыг бэлтгээгүй, саналын маягтыг бүрэн хөтлөөгүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.3 , 5.7 , 5.8 , 5.13 дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- *Санал өгсөн иргэдийн тоог сонгуулийн нийт хүн амын тоотой харьцуулаагүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 2/ - 7 сумын 20 баг,*
- *Төслийн хэрэгцээ, шаардлага, иргэдийн амьдралд нөлөөлөх нөлөөлөл, хэрэгжих төсөл, арга хэмжээнээс үр өгөөж хүртээгсдийн тоог тооцоогүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 5/ - 7 сумын 11 баг,*
- *Ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцсон /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 5/ - 8 сумын 12 баг,*

- *Батлагдсан төслийн танилцуулгыг бэлтгээгүй /ОНХС-ийн үйл ажиллагааны хавсралт 7/ - 7 сумын 16 баг.*

1.2.8 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг Баруунбүрэн, Сүхбаатар, Шаамар зэрэг сумдууд 2023 оны 5-6 дугаар сард байгуулсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.1 дэх заалтыг зөрчсөн байна.

1.2.9 Нийт 12 сумын ЗДТГ-ын ажлын хэсэг иргэдийн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар, тодруулга бэлтгээгүй нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.4.2 дахь заалтыг зөрчсөн байна..

1.2.10 Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт **615.0** сая төгрөгийн өртөг бүхий 12 төсөл арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн байна. Үүнд:

- Алтанбулаг сум “Зам шинээр барих”, “Хороолол дунд зам барих” зэрэг **350.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээ,
- Баруунбүрэн сум “Бухан бяруу худалдан авах”, “Богийн хээлтүүлэгч авах”, “Ивэнгийн 1-р багт оготно устгалын ажил хийх”, “Бургалтайн 2-р багт оготно устгал хийх” зэрэг **130.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ,
- Зүүнбүрэн сум “Малын гоц халдварт өвчний үед ашиглах халдваргүйжүүлэлтийн явуулын хяналтын цэг” **20.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ,
- Орхонтуул сум “Төрийн албан хаагчдын байр худалдан авах нэмэлт санхүүжилт”, “Орхонтуул сумын Рашаант тосгоны 1-р багт ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг сэргээн засварлах”, “Орхонтуул сумын Баянцогтын 2-р багт ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг сэргээн засварлах”, “Орхонтуул сумын Хонгор-Овоо 3-р багт ОНХС-н хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг сэргээн засварлах”, “Мал хулгайлах гэмж хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зориулан цагдаагийн албанд автомашин худалдан авах” зэрэг **115.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ.

1.2.11 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах **101.7** сая төгрөгийн дараах 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Сүхбаатар сумын “Сүхбаатар сумын 1-8 дугаар багт хаягжуулалт хийх”-д **99.8** сая төгрөг,
- Хүдэр сумын “Малчдын тоо толгойн албан татварын ажлын шатахууны зардал”-д **2.0** сая төгрөг,

1.2.12 Сумдын ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх нийт **3,711.1** сая төгрөгийн **52** төсөл арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр баталсан байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав/


БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 68.5 ХУВЬ, САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ 58.6 ХУВЬТАЙ БАЙНА.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журмын холбогдох заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ОНХС:

2.1.1 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр нийт 14,247.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 төсөл, арга хэмжээ /1,146.3 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих бол 13,101.6 сая төгрөгийн 54 төсөл арга хэмжээ нь шинээр эхлэх/ баталснаас 7,913.0 сая төгрөгийн 44 төсөл арга хэмжээ бүрэн /гэрээний дүнгээр/, 1,640.1 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ /гэрээний дүнгээр/ дутуу хэрэгжиж, 874.6 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-аас харах/

Дүрслэл 1. Аймгийн ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/



Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.1.2 Өмнөх оноос шилжин хэрэгжих 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, шинээр хэрэгжих 13,101.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 54 зэрэг нийт 13,151.6 сая төгрөгийн 55 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 12,578.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулсан байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-оос харах/ Үүнд:

- 9,113.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,
- 888.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,

- 2,276.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар гэх мэт.

2.1.3 Тайлант онд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34.1.5 дахь заалт болон аймгийн Онцгой комиссын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийн дагуу дараах 535.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

- Төмөр замын гармын 25 дугаар хэсэгт нүхэн гарц байгуулах /Сүхбаатар сум, 8-р баг/ 500.0 сая төгрөг,
- “Гемодиализийн эмчилгээний ус цэвэршүүлэх аппарат /Нэгдсэн эмнэлэг/” 35.0 сая төгрөг.

2.1.4 Дараах 573.3 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна. Үүнд:

- Захиалагч байгууллагаас худалдан авах ажиллагааг явуулахад шаардлагатай баримт, материал, зураг төсөв ирүүлээгүй шалтгааны улмаас 55.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Моргийн барилгын их засвар /Орхонтуул сум, Рашаант тосгон/” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй,
- Худалдан авах ажиллагааг тус бүр 2 удаа зохион байгуулсан боловч санал ирээгүйгээс 518.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна. Тухайлбал:
 - ✓ Номт хан өрхийн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Сүхбаатар 4-р баг Баянхан/ 173.0 сая төгрөг,
 - ✓ Сургуулийн их засвар /Мандал сум, 3-р сургууль/ 300.0 сая төгрөг,
 - ✓ Зам засвар /Сүхбаатар сум/ 45.3 сая төгрөг

2.1.5 “Студийн тоног төхөөрөмж, тайз, хөгжим /Сэлэнгийн долгио чуулга/” 204.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг НТШ-ын журмаар 2 удаа зарлаж, тендер амжилтгүй болсон тул гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримтыг бүрдүүлээгүй байна.

2.1.6 Худалдан авах ажиллагааны тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар баталсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулж, худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна.

2.1.7 Аймгийн ОНӨГ нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.2⁴-т заасны дагуу Сангийн яаманд цахим системээр хүргүүлсэн байна.

2.1.8 “Мандал сумын нэгдсэн эмнэлгийн дотрын тасаг, дэмжих төвийн засвар” 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний зураг төсвийн үнэ болох 3.0 сая

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч ... тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг ... төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

төгрөгийг зохиогчид бус төсөвт тусгагдаагүй нэмэлт ажил /39 ширхэг хаалганд цоож суулгах, 29 ширхэг холигч шинээр хийх/ гүйцэтгэсэн акт, баримтыг үндэслэн гүйцэтгэгчид олгосон байна. /Жич: Гүйцэтгэгч нь магадалшгүй ажлын зардал 4.8 сая төгрөгөөр засварын ажлын төсөвт тусгагдаагүй хаалганы амлагааг шинээр хийх ажлыг гүйцэтгэж, акт, холбогдох баримтаар баталгаажуулж санхүүжилтийг авсан./

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.5⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

2.1.9 Төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Хурлын тэмдэглэл болон тооцсон төсөвгүйгээр 13 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардалд 36.8 сая төгрөг олгосон. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-д харуулав/,
- 832.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээний чанарын баталгаа 33.4 сая төгрөгийг “Хөрөнгө оруулалтын барьцаа” дансанд байршуулаагүй байна. Тухайлбал:
 - ✓ “Эргэлтийн эмийн сан байгуулах /Хушаат сум/” 60.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээнд “Чанарын баталгаа 5 хувь байна” гэж заасан боловч 3.0 сая төгрөгийн барьцаа тооцоогүй,
 - ✓ “Төмөр замын гармын 25 дугаар хэсэгт нүхэн гарц байгуулах /Сүхбаатар сум, 8-р баг/” 500.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээнд гэрээний дагуу 25.0 сая төгрөгийн барьцааг тооцсон боловч “Хөрөнгө оруулалтын барьцаа” дансанд төвлөрүүлээгүй,
 - ✓ “Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих /Баруунбүрэн сум/” 272.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний гэрээнд чанарын баталгааг 3 хувь гэж тусгаснаас барьцааг 5.4 сая төгрөгөөр дутуу тооцсон.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43.6⁶ дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.5⁷, 4.8.17⁸ дахь заалтуудыг зөрчсөн байна.

2.1.10 Аймгийн Засаг даргын 2023 оны А/659 дүгээр захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь бүрэн дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 112.3 сая төгрөгийн санхүүжилтийг “Хөрөнгө оруулалтын барьцаа”

⁵ Төсөл, арга хэмжээний ... зураг төслийн үнэ ... тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх,

⁶ Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно.

⁷ Төсөл, арга хэмжээний ... чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, ... холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх,

⁸ 4.8.17. Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно;

дансанд, 5 төсөл арга хэмжээний 8.3 сая төгрөгийн зураг төсөв, зохиогчийн хяналтын зардлыг “Техник хяналт” дансанд тус тус төвлөрүүлсэн байна.


2.1.11 Өмнөх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 төсөл арга хэмжээний чанарын баталгаа 50.3 сая төгрөгийг “Хөрөнгө оруулалтын барьцаа” дансанд шилжүүлж, тайлант онд олгохдоо ОНХС-ийн дансаар дамжуулалгүйгээр шууд гүйцэтгэгчид шилжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.1-д “ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- “Сайхны хөтөлд баригдах шилэн гүүр цогцолборын тохижилтын ажил”-ын 38.0 сая төгрөг,
- “Сүхбаатар сумын Хуримын ордны хүчитгэлийн ажил”-ын 12.3 сая төгрөг.

Сумдын ОНХС:

2.1.12 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр нийт 18,666.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 306 төсөл, арга хэмжээ баталснаас 9,945.6 сая төгрөгийн 207 төсөл арга хэмжээ бүрэн /гэрээний дүнгээр/, 3,101.8 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ /гэрээний дүнгээр/ дутуу хэрэгжиж, 4,062.6 сая төгрөгийн 80 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 3-аас харах/

Дүрслэл 2. Сумдын ОНХС-ийн гүйцэтгэл /сая төгрөг/



Эх үүсвэр: Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.1.13 2023 онд шинээр хэрэгжүүлэх 16,711.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 282 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 13,704.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 223 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Үүнд:

- 8,049.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар,
- 3,355.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 62 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар,

- 2,047.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 116 төсөл, арга хэмжээг гэрээ шууд байгуулах аргаар,
- 252.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг олон нийтийн оролцоотой худалдан авалтын аргаар тус тус гүйцэтгэсэн байна.

2.1.14 Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэснээс худалдан авах ажиллагаа оройтсон, хандивын эх үүсвэр бүрдээгүй, малын тоо толгойн албан татварын орлого дутуу төвлөрсөн зэрэг шалтгааны улмаас 3,007.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 59 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

2.1.15 Гүйцэтгэгчийг сонгох харьцуулалтын аргаас зайлсхийж Шаамар, Сайхан сум нь ижил төстэй **147.2** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тус бүр 2-3 хуваан төлөвлөж, гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4⁹, 8.5¹⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Шаамар сум: “Герефорд бух худалдаж авах”, “ЗДТГ-т сайн чанарын үнээ худалдаж авах”, “Малжуулах ажлын хүрээнд ЗДТГ-т тугалтай үнээ худалдаж авах” 52.2 сая төгрөг,
- Шаамар сум: “1-р баг Хөдөө нуурт худгийн цооног гаргах”, “1-р багт Ундрагчийн доор худгийн цооног гаргах” 35.0 сая төгрөг,
- Орхонтуул сум: “Орон сууцны хорооллын 14-р байрнаас 13-р байрны оролт хүртэл инженерийн шугамыг солих ажил”, “Орон сууцны хорооллын ТК-10 худгаас ТК-11 худга хүртэл инженерийн шугамыг солих ажил”, “Орон сууцны хорооллын ТК-6 худгаас 9-р байрны оролт хүртэл инженерийн шугамыг солих ажил” 60.0 сая төгрөг,

2.1.16 Сүхбаатар, Хүдэр сум ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 101.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын ажлын шатахууны зардал /Хүдэр сум/ 2.0 сая төгрөг,
- Сүхбаатар сумын 1-8 дугаар багт хаягжуулалт хийх 99.7 сая төгрөг.

2.1.17 Сүхбаатар, Хушаат сум нь ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар /төсөв хэтрүүлсэн/ зарцуулсан байна. Үүнд:

- Сүхбаатар сум нь 35.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Үндэсний баяр наадам”-ын батлагдсан төсвийг 1.9 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан,
- Хушаат сум нь 81.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид 0.4 сая төгрөгийг илүү олгосон.

2.1.18 2 төсөл, арга хэмжээний тендерийн хэмнэлт болох 30.8 сая төгрөгийг гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээ байгуулж, олгосон байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

⁹ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

¹⁰ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

- Спиртийн 5-р байрнаас Мандал хотхон хүртэл 0.61 км /Мандал сум/ 247.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Ноблероуд ХХК-тай 27.8 сая төгрөгийн нэмэлт гэрээ,
- Сумын нэгдсэн граш агрегат засварын төв /Орхон сум/ 246.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Нарт Оргил Өргөө ХХК-тай 3.0 сая төгрөгийн нэмэлт гэрээг тус тус байгуулж, олгосон.

2.1.19 Сүхбаатар сум нь өмнөх оноос шилжин хэрэгжих 236.5 сая төгрөгийн санхүүжүүлэх дүн бүхий "7-р багт нийтийн эзэмшлийн жишиг гудамж, талбай байгуулах" төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжүүлэх дүнд тусгагдаж сумын ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй зураг, төсвийн үнэ болох 16.0 сая төгрөгийг Мандахтовер констракшн ХХК-д шилжүүлсэн.

2.1.20 Төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- 2023 онд хэрэгжиж дуусахаар гэрээ байгуулсан ажлууд тогтоосон хугацаанд ашиглалтад ороогүй боловч гэрээний хугацаанд өөрчлөлт оруулаагүйгээс хугацаа хэтэрсэн 12 төсөл арга хэмжээнд 9.3 сая төгрөгийн алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 5-д харуулав/
- Алтанбулаг, Орхонтуул, Сайхан, Сант, Түшиг сумд нь акт, хурлын тэмдэглэлгүйгээр магадалшгүй ажлын зардалд 16.1 сая төгрөг олгосон. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-д харуулав/
- Зүүнбүрэн сум нь 125.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээнд "Чанарын баталгаа 5 хувь байна" гэж заасан боловч 5.6 сая төгрөгийн чанарын баталгааг гэрээний дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна. Тухайлбал:
 - ✓ Соёлын төвийн тайзны гэрэлтүүлэг 30.0 сая төгрөг,
 - ✓ Байгалийн гамшиг ослын үед авран хамгаалах, зам даваа засах тусгай тоног төхөөрөмж худалдан авах 95.0 сая төгрөг.
- Мандал сум нь "Хүлээн авсан комиссын акт"-аар баталгаажуулалгүйгээр 124.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээнд 122.6 сая төгрөгийн эцсийн санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.9.1.6¹¹, 4.10.1.2¹²-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал:
 - ✓ Малын тарилга хийх зөөврийн хашаа, ванн авах /2 ширхэг/ 70.0 сая төгрөг
 - ✓ Худаг гаргах /2 ширхэг/ 54.0 сая төгрөг

2.1.21 12 сумд нь гэрээний биелэлт, үр дүнг "Гэрээ дүгнэх маягт"-аар үнэлж, баталгаажуулалгүйгээр нийт 2,085.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл, арга хэмжээнд 1,961.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.29-д заасныг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 6-д харуулав/

¹¹ захиалагч нь эцсийн санхүүжилт хүсэх барилга байгууламжийн төслийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

¹² захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй байна.

2.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т “ ... ОНХС-ийн хөрөнгөөр ... барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх **хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ**” гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.2.2 Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 32,914.6 сая төгрөгийн 366 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 251 төсөл, арга хэмжээ буюу 68.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 төсөл, арга хэмжээ буюу 7.7 хувь нь дутуу хэрэгжсэн, 87 төсөл, арга хэмжээ буюу 23.8 хувь нь огт хэрэгжээгүй байна.

Хүснэгт 4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа /хувиар/

№	Аймаг, сум	ИТХ-аар батлагдсан		Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Огт хэрэгжээгүй	
		Тоо	Дүн	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Алтанбулаг	9	599.1	8	88.9	1	11.1		
2	Баруунбүрэн	25	832.4	10	40.0	1	4.0	14	56.0
3	Баянгол	11	1,473.1	9	81.8	2	18.2		
4	Ерөө	21	3,040.9	11	52.4	2	9.5	8	38.1
5	Жавхлант	18	494.6	13	72.2	1	5.6	4	22.2
6	Зүүнбүрэн	17	491.8	9	52.9			8	47.1
7	Мандал	27	3,878.5	20	74.1	4	14.8	3	11.1
8	Орхон	14	542.6	13	92.9			1	7.1
9	Орхонтуул	27	1,114.3	19	70.4			8	29.6
10	Сайхан	20	1,058.6	14	70.0			6	30.0
11	Сант	25	513.0	19	76.0	1	4.0	5	20.0
12	Сүхбаатар	13	1,102.9	11	84.6	1	7.7	1	7.7
13	Түшиг	14	490.8	7	50.0	3	21.4	4	28.6
14	Хушаат	21	524.9	18	85.7	1	4.8	2	9.5
15	Хүдэр	8	768.2	5	62.5			3	37.5
16	Цагааннуур	23	1,265.6	13	56.5	2	8.7	8	34.8
17	Шаамар	13	475.5	8	61.5			5	38.5
	Сумын дүн	306	18,666.7	207	67.6	19	6.2	80	26.1
18	Аймгийн ОНХС	60	14,247.9	44	73.3	9	15.0	7	11.7
	Нийт дүн	366	32,914.6	251	68.5	28	7.7	87	23.8

Эх сурвалж: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.2.3 Аудитын дүнгээс харахад төсөл, арга хэмжээнүүд нь дор дурдсан шалтгааны улмаас дутуу болон огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Иргэдийн саналгүй, зураг төсөө, тооцоо судалгаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан,

- Худалдан авах ажиллагааг оройтуулсан, ажил гүйцэтгэх боломжгүй хугацаанд гэрээ байгуулсан,
- Худалдан авах ажиллагааг давтан зарласан боловч оролцогч санал ирүүлээгүй,
- Малын тоо толгойн албан татварын орлого бүрдээгүйгээс санхүүжилт хүрэлцэхгүй байх гэх мэт.

2.2.4 ОНХС-ийн хөрөнгийг бүс нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн явган хүний зам, сайжруулсан болон хатуу хучилттай зам тавих, засварлах, гүүрийн байгууламж барьж байгуулах /8,388.6 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээ/, орчны тохижилт, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх /1,702.5 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээ/, хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулж, тохижуулах /1,532.0 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ/, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, цахилгаан, дулааны шугамд холбох ажилд /1,552.6 сая төгрөгийн 15 төсөл арга/ түлхүү байдлаар төлөвлөж зарцуулсан нь иргэдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, орон нутгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа сайн талууд оршиж байна.



Хатуу хучилттай авто зам болон авто зогсоолын шинэчлэл /Сүхбаатар сум/ 1,400.0 сая төгрөг



Эрүүл мэндийн төвийн барилга /Цагааннуур сум/ 320.0 сая төгрөг



1900 м бетонон замыг асфальтаар хучих, 2.9км дугуйн зам шинээр тавих /Ерөө сум/ 1,053.0 сая төгрөг

2.2.5 Нөгөө талаас ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэсэн, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь сангийн мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал:

- *Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой соёлын байгууллагад студийн тоног төхөөрөмж, хөгжим худалдан авах, нэгдсэн эмнэлэгт Гемодиализийн эмчилгээний ус цэвэршүүлэх аппарат, сумын эрүүл мэндийн төвд шүдний кабинет байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах, сургуулийн кабинет тохижуулах зардлуудад нийт 191.7 сая төгрөгийг зарцуулсан байна.*
- *Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэт жижиглэсэн буюу 1.0-20.0 хүртэл сая төгрөгийн төсөвт өртөгтэй улсын төсвийн байгууллагын хөгжим, хувцас, гэрэлтүүлэг, лед дэлгэц, тоног төхөөрөмж, урсгал засвар, худаг, тоглоомын талбай, явган хүний зам, малын чанарыг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, малчдын сургалт зэрэг 109 төсөл, арга хэмжээнд 1,602.1 сая төгрөгийг зарцуулсан байна.*

2.2.6 ОНХС-ийн төлөвлөгөөнд хэдийгээр тодорхой хэмжээний иргэдийн эрх ашигт нийцсэн боловч тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих бус төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын болон дээврийн засварын 9 төсөл, арга хэмжээг 1,120.3 сая төгрөгөөр тусгаж, хэрэгжүүлсэн байна.

2.2.7 7 сум нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцааг тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүй, баримт материалыг нэгтгээгүй байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим хөрөнгийн ашиглалтын байдал хангалтгүй байна.

2.3.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зарим гүйцэтгэгчид нь гэрээнд заасан бараа, ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэсэн, захиалагч хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс зарим хөрөнгө ашиглалтгүй байна.

2.3.2 868.8 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг чанаргүй гүйцэтгэсэн, гүйцэтгэл дутуу зэргээс шалтгаалан улсын комисс хүлээж аваагүй байна. Үүнд:

- *ЕБС-ийн дотуур байрны хашаа /Түшиг сум/ 10.8 сая төгрөг,*
- *Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт /Түшиг сум/ 20.0 сая төгрөг,*
- *Уурын зуухны нөөцийн худаг /Алтанбулаг сум/ 28.0 сая төгрөг,*
- *Отоглох цэг байгуулах /Баруунбүрэн сум/ 60.0 сая төгрөг,*
- *Баянбулаг гудамжнаас Сансар гудамж хүртэл 2 км авто зам /3, 7-р баг/ /Мандал сум/ 750.0 сая төгрөг,*

2.3.3 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч дараах хөрөнгүүдийг ашиглахгүй, эсвэл зориулалт бусаар ашиглаж байгаа нь хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг бууруулж байна. Үүнд:

- *Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр Шаамар суманд хэрэгжсэн 132.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ажлын байрны барилга”-ыг ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлсэн боловч тайлант онд ашиглаагүй,*
- *Хушаат сум нь 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Евро хашааны тоног төхөөрөмж” худалдан авсан боловч одоог хүртэл ашиглаагүй.*

2.3.4 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн хөрөнгүүдийн харуул хамгаалалт, ашиглалт, урсгал зардал тодорхой бус байгаагаас эдгээр хөрөнгүүд эзэнгүйдэх, эвдэрч, гэмтэх эрсдэлтэй байна.

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАНГ НЭГТГЭЖ ХҮРГҮҮЛЭЭГҮЙ, ДОТООД ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал буурахгүй байна.

3.1.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг.

3.1.2 Аймгийн болон Сайхан, Сүхбаатар сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/

3.1.3 Харин хяналт хэрэгжүүлсэн сумдын ИТХ-ын дэргэдэх хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг иргэдийн санал авч, эрэмбэлсэн эсэх, багийн ИНХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх, зураг, төсөв, тооцоо, судалгаа нь урьдчилан хийгдсэн, худалдан авах ажиллагаа зэрэг эрсдэлтэй асуудлыг хяналтад хамруулалгүйгээр зөвхөн хэрэгжилт, гүйцэтгэл, ашиглалтад хүлээн авсан эсэхийг хамруулсан байна.

3.1.4 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг Баруунбүрэн, Баянгол сум нь бүрэн, Мандал сум дутуу, бусад сумдууд огт хэрэгжүүлээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 5-аас харах/

3.1.5 Тайлант онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хяналт огт хийгдээгүй байна.

3.1.6 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аймаг, сумдын ОНХС-ийн 2023 оны үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй байна.

3.1.7 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн нийт **214.6** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **5** төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй нь Барилгын

тухай хуулийн 37.2¹³ дахь, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁴, 3.9¹⁵ дэх заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Орхон сумын 66.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бэлэндалайд гүний худаг гаргах, “Бэлэндалай багийн Овоотод худаг гаргах”, “Сумын нэгдсэн авто гаршид дулаан холболт хийх” 3 төсөл арга хэмжээ,
- Сайхан сумын 148.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бичил хорооллын дундах сүүдрэвчийг нэмэгдүүлэх, “Орон сууцны хорооллын 14-р байрнаас 13-р байрны оролт хүртэл инженерийн шугамыг солих ажил”, 2 төсөл арга хэмжээ.

3.1.8 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэн, аймаг, сумдын дүнгээр нийт 8,498.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.1.9 Өмнөх онд хийгдсэн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тайлант онд алдаа зөрчлийг давтан гаргасан Баруунбүрэн, Ерөө, Мандал, Орхон, Сүхбаатар, Түшиг сумдын Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, холбогдох мэргэжилтнүүдэд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1¹⁶-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу нэгтгэн тайлагнаж хүргүүлээгүй байна.

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь заалтуудын дагуу бүх сумдууд ОНХС-ийн 2023 оны хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлээгүй, ХБТХОХ нь сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна.

3.2.2 Аймаг, сумын ЗДТГ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл

¹³ Захиалагч барилгын ажлын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁴ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁵ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

¹⁶ Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, ... хугацаанд нь биелүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

ажиллагаанд хяналт- шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.


3.2.3 Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүйгээс 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн яаманд хүргүүлээгүй байна.

3.2.4 Аймаг, сумын ЗДТГ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон дараах 1,642.1 сая төгрөгийн 14 хөрөнгийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй байна. */Дэлгэрэнгүйг Судалгаа 12-аас харах/*

3.2.5 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,120.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, нийтийн эзэмшлийн байр болон дээврийн засварын 9 төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг */бүртгэлд тусгах хууль эрх зүй нь тодорхой бус/* бүртгэлд тусгах боломжгүй байна.

3.2.6 Аудитын явцад Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтын дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах 8 сум нь 1,316.6 сая төгрөгийн 43 төсөл арга хэмжээний мэдээллийг нээлттэй ил тод мэдээлээгүй байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 3. Удирдлагын мэдээллийн системд байршуулаагүй мэдээлэл /сая төгрөг/



Эх үүсвэр: ОНХС-ийн удирдлага мэдээллийн систем

3.2.7 Сангийн яам нь удирдлага мэдээллийн системийн “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” цэсээр аймаг, сумдын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнг үнэлж дүгнээгүй байна.

3.2.8 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3 дахь

заалтуудыг зөрчин аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтын талаарх явцын мэдээллийг удирдлага мэдээллийн системд оруулаагүй байхад тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг гүйцэтгэсэн алдаа зөрчил давтагдсаар байна.

3.2.9 Аудитын явцад Шилэн дансны тухай хуулийн дагуу сар бүр тогтмол мэдээлэх ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 12 мэдээлэл, жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн 2 мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн мэдээлбэл зохих 2 төрлийн 13 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг /сар бүр мэдээлэх ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ/ огт мэдээлээгүй байна.
- Сумдын ОНХС-ийн мэдээлбэл зохих 2 төрлийн 221 мэдээллээс 123 мэдээллийг хугацаанд нь, 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 51 мэдээллийг дараах сумууд огт мэдээлээгүй байна. /сар бүр мэдээлэх ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ/ /Дэлгэрэнгүйг Хавсралт 7-д харуулав/

3.2.10 ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн мэдээлж байх шаардлагатай байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар аймаг, сумдын дүнгээр нийт 13,245.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 11,928.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 1,316.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

Төлбөрийн акт:

- Хушаат сум нь 81.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид 0.4 сая төгрөгийг илүү олгосон.

Албан шаардлага:

Аймгийн ОНХС: 5,807.0 сая төгрөгийн зөрчил /зөрчил давхардсан төсөл, арга хэмжээг нэгтгэсэн/

- Иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт **1,280.4** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн,
- **2,109.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-аар батлуулсны дараа хийлгэсэн,
- Гэрээ шууд байгуулахдаа хуулийн шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримтыг бүрдүүлээгүй **204.2** сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ,
- 3 төсөл, арга хэмжээний гэрээнд тусгагдсан **33.4** сая төгрөгийн чанарын баталгааг барьцаалаагүй,
- Магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр 13 төсөл арга хэмжээнд **36.8** сая төгрөгийг олгосон,

- Төсөл арга хэмжээний зардлыг бүрэн зөв тооцоогүйгээс **3.0** сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж санхүүжүүлсэн,
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон **2,140.2** сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.

Сүмдын ОНХС: 6,121.7 сая төгрөгийн зөрчил /зөрчил давхардсан төсөл, арга хэмжээг нэгтгэсэн/

- Алтанбулаг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Орхонтуул сумд нь иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт **615.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн,
- Мандал сум нь ОНХС-ийн /МТТАТ-ын эх үүсвэрээр/ хөрөнгөөр хэрэгжүүлэх **208.6** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг арга хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталсан,
- 13 сум нийт **3,711.1** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-аар батлуулсны дараа хийлгэсэн,
- Сүхбаатар, Хүдэр сум нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах **101.7** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн,
- Сүхбаатар сум нь ИТХ-аар батлагдаагүй зураг, төсвийн үнэ **16.0** сая төгрөгийг олгосон, 35.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Үндэсний баяр наадам”-ын батлагдсан төсвийг **1.9** сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан,
- Сайхан, Шаамар сумд нь нийт **147.2** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг нээлттэй болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаас зайлсхийх зорилгоор төсөвт өртгийг 2 хуваан төлөвлөж, худалдан авах ажиллагааг харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэсэн,
- Алтанбулаг, Орхонтуул, Сайхан, Сант, Түшиг сум нь магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулалгүйгээр 8 төсөл арга хэмжээнд **16.1** сая төгрөгийг олгосон,
- Баянгол, Орхон, Сайхан сумд нь нийт **673.9** сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээний ажлын явц болон гүйцэтгэлд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй,
- Зүүнбүрэн сум нь 2 төсөл, арга хэмжээний гэрээнд тусгагдсан **6.0** сая төгрөгийн чанарын баталгааг барьцаалаагүй,
- Алтанбулаг, Орхон, Орхонтуул, Цагааннуур сум нь **9.3** сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээнд алданги тооцолгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс Мандал, Орхон сумд **30.8** сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж санхүүжүүлсэн,

- Ерөө, Зүүнбүрэн, Сүхбаатар, Хушаат сумд нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 9 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон **584.1** сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй.
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан 6 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. МТТАТ-ын орлогоос ОНХС-д олгох санхүүжилтийг 1,452.7 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлснээс эх үүсвэр дутагдаж зарим төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.
2. Аймаг, 12 сум нь иргэдийн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдсан эсэхийг харгалзаж үзээгүй, төсөл арга хэмжээний жагсаалтыг журмын дагуу бэлтгээгүй байна.
3. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 23.8 хувь огт хэрэгжээгүй нь 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 18.7 хувьд худалдан авах ажиллагаа зарлаагүйгээс голлон шалтгаалсан байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэсэн, захиалагч хэрэгцээ шаардлагыг бодитой төлөвлөөгүйгээс зарим хөрөнгө ашиглалтгүй байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд дотоод аудит огт хийгдээгүй, ИТХ-ын зүгээс зөвхөн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлсэн, харин захиалагчийн хяналтыг зарим төсөл арга хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.
6. ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг гаргаагүй, нэгтгэж хүргүүлээгүй, удирдлагын мэдээллийн системд 8 сум нь 1,316.6 сая төгрөгийн 43 төсөл арга хэмжээний мэдээллийг оруулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:


1. ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт хийж, дүнг хэлэлцэх.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

1. Жилийн эцсийн малын тоонд үндэслэн МТТАТ-ын орлогыг бодитоор төлөвлөж, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг ОНХС-ийн дансанд бүрэн шилжүүлэх.
2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөж, ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан төсөл, арга хэмжээний саналыг нээлттэй хэлэлцүүлсний үндсэн дээр ИТХ-д өргөн мэдүүлэх.
3. ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөж, бүрдүүлэн, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.

4. Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үүргийг хангуулах, хариуцлага тооцох замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх.
5. ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд хяналтыг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэж, шийдвэрлэх.
6. ОНХС-ийн хэрэгжилтийг тайлагнах, нэгтгэж хүргүүлэх, төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийг цахим системд ил тод нээлттэй мэдээлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Т.БОЛОР

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081

Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn

Цахим хуудас: www.selenge.gov.mn


2024.07.04 № 01/871

танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Иймд Аудитын дүгнэлттэй санал нийлж байгаа тул илэрсэн зөрчлийг арилгах ажлуудыг дахин давтахгүйгээр ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ  Ж.САЙНЦОГ



C:user/albanbichig2024/jijig tootA5

430801020



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.04 № 63
танай _____-ны № _____-т


АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Т.БАЙГАЛЬМАА ТАНАА

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны
бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлан болон хавсралт,
судалгааг гаргаж хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

C:/Bichig hereg/2024/Alban bichig A5.Docx

018033095



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 7/12

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.


2. Аудитын тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ-ын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж) болон сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Т.Болор)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА